



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 10 өдөр

Дугаар 446

Арвайхээр

Өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Өвөрхангай аймгийн Онцгой комиссын 2020 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 01 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын онцгой комиссиоос 2019 оны 11 дүгээр сард аймгийн өвөлжилтийн нөхцөлд хийсэн үнэлгээгээр 16 суманд эрсдэлийн түвшин их, 2 сум дунд, 1 сум бага эрсдэлтэй гарсан байх тул зудын эрсдэлийг хохирол багатай даван туулах зорилгоор аймгийн өвс тэжээлийн аюулгүйн нөөцөд 10000 (арван мянга) боодол нарийн шар өвсийг 96000000 (ерэн зургаан сая) төгрөгөөр, 1000 (нэг мянга) боодол ногоон өвсийг 11500000 (арван нэгэн сая таван зуун мянга) төгрөгөөр “ӨВ Баян борх” ХХК-иас, 2000 (хоёр мянга) боодол ногоон өвсийг 23000000 (хорин турван сая) төгрөгөөр А.Эрдэнэбаатараас (йт71082510) худалдан авахыг зөвшөөрсүгэй.

2. Шалгарсан аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж, өвс тэжээлийг чанар, баглаа боодол, гарал үүсэл зэрэгт хяналт тавьж, хуваарилалт хийхийг аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газар (С.Цэдэнбалжир)-т даалгасугай.

3. Гэрээнд заасан хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Г.ГАНБОЛД



011100113